

## МОНГОЛ ОРООНД *Larus heuglini*-НЫ ХОЁР ДАХЬ ТОХИОЛДОЛ ТЭМДЭГЛЭГДЭВ

Гүнгаагын Амархүү<sup>1</sup>, Батбаярын Нямбаяр<sup>1</sup>, Батмөнхийн Баатархүү<sup>1</sup>, Дамбын Идэрбат<sup>2</sup>,  
Нацагдоржийн Цэвээнмядаг<sup>2</sup>

<sup>1</sup>Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Ундрал Плаза 33 тоот, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар 210349

<sup>2</sup>Шүүвүү судлалын лаборатори, Биологийн хүрээлэн, Энхтайвны өргөн чөлөө 54Б, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар 210351

харилцах хаяг: amarkhuu@wsc.org.mn

Тоодог 1:34-35, 2014

**abstract.** During a recent waterbird survey to eastern Mongolia, we photographed a single Heuglin's Gull on 22 September 2014 at Gurem Lake in Dornod Province. This is the second and proof record of this species for Mongolia. Based on subspecies distribution and wintering locations, this individual could belong to subspecies *L. h. taimyrensis*

**Keywords:** *Larus heuglini*, шинэ зүйл

Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв болон ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу судлалын лаборатори хамтран цэн тогоруу болон усны шувуудын намрын нүүдлийн судалгааг 2014 оны 9 сарын 20-аас 10 сарын 7-ны хугацаанд Монгол орны зүүн бүсийн нутгаар хийж гүйцэтгэсэн. Судалгааны хугацаанд замналын дагуу таарах гол, нуур, ус намгархаг газруудаар усны шувуудын ажиглалтыг хийсэн ба тэдгээрийн нэг нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын төвөөс хойш орших Гүрэмийн нуур (N: 47.827111° E: 112.139324°) байв. Бид энэ нууранд 2014 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр ирсэн. Нууранд хос Гангэр хун (*Cyggnus cygnus*), 12 Хондон ангир (*Tadorna ferruginea*) мөн нэг зүйл ганцаар байх цахлагай бүртгэсэн. Энэхүү цахтай нь Монгол оронд түгээмэл тохиолдох мөнгөлөг цахтайгаас *Larus mongolicus* ондоо харагдсан тул бид тодруулах үүднээс зургийг нь авч баталгаажуулсан.

Уг цахтай нуурын баруун эрэг дээр ганцаар байсан ба биднийг зураг авахаар нууранд ойртох үед нисэн дахин ирэлгүй холдсон. Гэвч бид цахлагай зүйлийн түвшинд танихуйц хэмжээний зургийг авч чадсан юм. Бид тус цахлан зургийг цахлан чиглэлээр олон жил ажилласан Германы шувуу судлаач Андреас Буххейм болон Аксэл брайнилих руу өөрсдийн таамаглалын хамт илгээсэн. Түүний баталсанаар энэхүү цахтай нь Heuglin's Gull (*Larus heuglini*) бөгөөд Монголд хоёр дах



Хэүглин цахтай *Larus heuglini*, Гүрэмийн нуур,  
зургийг Г.Амархүү

удаагаа бүртгэгдэж буй тохиолдол болно. Энэ зүйл цахтайг 2005 онд Дорнод аймгийн Сүмбэр сумын нутагт орших Хонхор шуумар нууранд 2 бодгалийг тэмдэглэж байсан боловч зураг авч баталгаажуулаагүй учир Монгол орны шувуудын жагсаалтанд албан ёсоор бүртгээгүй байна (Badley et al. 2005).

Бид энэ зүйлийг Монголоор Хэүглин цахтай хэмээхийг санал болгож байна. Хэүглин цахтай нь Европ ялангуяа тундрын бүс нутгууд, Оросын хойд хэсгээр үржлийн тархалттай ба биеийн өндөр нь 53-70 см, далавчны дэлгээцийн урт нь 138-158 см хүрдэг том биетэй цахлануудын нэг юм. Үржлийн нутагтаа хосоор эсвэл цөөн тооны хосууд нийлж голын эрэг болон нуураар тархан үржинэ. Уг цахлан нүүдлийн талаарх мэдээлэл дутмаг байхаас гадна ангилал зүйн асуудал маргаантай хэвээр байгаа

Дэлхий дээр Хэуглин цахлайн 2 салбар зүйл болох *Larus heuglini heuglini*, *Larus heuglini taimyrensis* бүртгэгдсэн байдаг. *L. h. heuglini* нь Оросын Марианы арлаас Цагаан тэнгис, Коли Хойг мөн баруун Тамиур хүргэл үрждэг. *L. h. taimyrensis*-тэй харьцуулахад *L. h. heuglini*-ны судалгаа Европ талдаа харьцангуй сайн хийгдсэн байна. *L. h. heuglini*-ны нүүдэл намар 9, 10 сард эхэлдэг бөгөөд Газар дундын тэнгисийн зүүн хэсэг, Арабын тэнгис, Улаан тэнгис, мөн Энэтхэгийн далай хүрч өвөлждөг (Hooyo et al. 1996, Garner 1997). Эндээс хараадад *L. h. heuglini*-ны нүүдэл харьцангуй баруун буюу Европын тал руугаа ажээ. Харин *L. h. taimyrensis*-ийн (зарим тохиолдолд Тамут Gull гэж нэрлэгддэг) үржлийн гол нутаг нь *L. h. heuglini*-ны адил Оросын тундрын бүс боловч харьцангуй баруун өмнөд хэсэг болох Тамиур, Енисей мөрөн, Кара тэнгис, Яамал хүргэл тархсан байдаг. Өвөлждөг бүс нутгийн тухайд *L. h. heuglini*-ээс зүүн тийш Зүүн азид тохиолдоно (Olsen and Larsson 2003). Иймд энэ хоёр салбар зүйл нь нүүдлийн зам, өвөлждөг нутгийн хувьд газарзүйн ялгаатай аж. *L. h. taimyrensis*-ийн намрын нүүдлийн замнал нь Байгаль нуур, түүний орчмоор дайрч Хятадын зүүн өмнөд хэсэг, Өмнөд Солонгос, Япон мөн Хонгконг хүрч өвөлждөг (Hooyo et al. 1996). Манай орны хувьд *L. h. taimyrensis* нь нүүдлийн үедээ дайран өнгөрөх боломжтой бөгөөд ялангуяа бидний бүртгэсэн Хэуглин цахтай нь салбар зүйлийн хувьд энэ байх магадлалтай байна.

## Талархал

Энэ зүйл цахлайл танихад тусласан Германы судлаач Andreas Buchheim болон Axel Braunlich нарт талархсанaa илэрхийлье.

## Ашигласан бүтээл

Badley, J., S. Busuttil, J. Brookhouse, S. Gombobaatar, O. Goroshko, S. Rowland, A. Rowlands, M.

Thomas, U. C., I. bird, a. s. i. E. M. A. g. o. three, o. s. d. M. September, and U.-B. W. RSPB. 2005.

Important bird areas survey in Eastern Mongolia (A report on three ornithological surveys during May – September 2004). Ulan-Baatar: WCS & RSPB.

Garner, M. 1997. Large white – headed Gulls in the United Arab Emirates. Emirates Bird Report **19**:94–103.

Hooyo, J. d., A. Elliott, and J. Sargatal, editors. 1996. Handbook of the Birds of the World - Volume 3. Hoatzin to Auks. Lynx Edicions, Barcelona.

Olsen, K. M., and H. Larsson. 2003. Gulls of Europe, Asia and North America. Helm Identification guides.